

## **АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Нэг. Үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан ба Ногоон хөгжлийн бодлого, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр тус тус 2015 онд батлагдаж, Хөгжсөн -Хөвсгөл-2030 хөгжлийн хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд хог хаягдлын менежментийг сайжруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, боловсруулах хэмжээг нэмэгдүүлэх, хог хаягдалд зарцуулах хөрөнгө санхүүг нэмэгдүүлж, байгальд ээлтэйгээр устгах чиглэлээр зорилтуудыг тодорхойлсон байдаг.

Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн нөлөөгөөр хог хаягдлын хэмжээ жил тутамд нэмэгдэхийн зэрэгцээ төрөл, бүтцийн хувьд ч өөрчлөгдөх болсон. Тухайлбал, Мөрөн сум 2008 онд жилд 21 мянган тонн хог хаягдал гаргадаг байсан бол 2016 оны байдлаар 40 мянган тонн хог хаягдал үүсч, 1 дахин нэмэгджээ.

Үүнээс төмөр металлын хаягдлыг оруулалгүйгээр дунджаар 2 хувь буюу 0,8 мянган тн-ыг нь дахин ашигласан байна. Гэвч хог хаягдлын мэдээллийн сангийн бүрдэл анхан шатандаа дутмаг байгаагаас тоо бүртгэл хангалтгүй байсаар байна. Хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байгаагийн гол шалтгаан нь бараа, бүтээгдэхүүний хэрэглээ огцом өсч байгаатай холбоотой юм. Тухайлбал, 2011 оны хэмжээнд улсын хэмжээнд импортоор авсан химийн бодис 8.9%, албан тасалгааны тоног төхөөрөмж, электрон бараа 28.6%, аккумулятор, хуучин дугуй 28.1%, хуучин автотээврийн хэрэгсэл 71.8%-иар тус тус өссөн байдаг.

Дээрх бараа, бүтээгдэхүүнээс гарч байгаа хаягдал нь аюултай, хортой хаягдлууд байдаг. Мөн хог хаягдлын дийлэнх хувийг дахин боловсруулах боломжтой хуванцар, лааз, цаас, шил, хүнсний хаягдал эзэлж байна. Улсын хэмжээнд 2016 онд дахин боловсруулах боломжтой 975,9 мян.тн хог хаягдал үүссэний 13,04% нь цаас, цаасан бүтээгдэхүүн, 5,33% нь шил, шилэн бүтээгдэхүүн, 0,55% нь хөнгөн цагаан, 14,48% нь хар төмөрлөгөн бүтээгдэхүүн, 9,54% нь хуванцар бүтээгдэхүүн, 57,06% нь бусад бүтээгдэхүүний гаралтай хаягдал байна. Үүнээс 0,31% -ийг л дахин боловсруулж байна. Харин Мөрөн сумын хувьд хүнсний хаягдал 10%, цаас 8%, хуванцар 8%, шил 19%, метал 2%, бусад 51% хог гарсан судалгаа байдаг ч энэ бол зөвхөн хогийн цэгт хаягдаж байгаа хогонд хийсэн судалгаа юм. Үүнээс харахад баялагийг бид шууд хог дээр хаяж байгааг харж болох ч эргээд хог хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн хийх явцад төрийн болон ААН-ийн нягт хамтын ажиллагаа, дэмжлэг хэрэгтэй байдагаас манай аймгийн хэмжээнд ийм үйлдвэрлэл, үйлчилгээ байхгүй байна.

Одоо аймгийн хэмжээнд 24 сум, суурин газарт нийт 25 хог хаягдлын төвлөрсөн цэг, нийт хогтой талбай 150 га-г хамарч байна. Зөвхөн ердийн хог хаягдал төдийгүй химийн хорт бодис агуулсан хаягдалууд болох барилгын хаягдал, аккумулятор, цахилгаан

хэрэгсэл, ашигласан тос, бүх төрлийн зай, зай хураагуур, мөнгөн ус агуулсан хэмжилтийн багаж, хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн лаг зэрэг үйлдвэрлэл, ахуйгаас гарах аюултай хог хаягдлын хэмжээ ч ихэсч, ил задгай, хур хуримтлал бий болсоор байна.

Аймгийн төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн асуудал үүний тод жишээ болж байна. Уг цэгийн талбай ихэсч 40 га талбайд хог хаягдаж, олон жил хог хаяж байгаа далангаас шаталт явагдаж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгааг үндэслэн БОХНСЗардлаас 20 сая төгрөгийг хуваарилан шаталтыг зогсоож, хуучин цэгийг хааж, талбайг өөрчилсөн, гэвч цаашид харуул хяналтыг сайжруулж, ландфиллийн технологиор хогийг дарж булахгүй бол эргээд шинэ цэгээс шаталт явагдах, агаар, хөрс бохирдуулах эрсдэлтэй.

Мөн сумдын хогийн цэгт шаталт буурахгүй байгаа нь хог хаягдлыг устгаж байгаа мэт боловч агаарт маш хортой аюултай хийг ялгаруулж байдаг. Үүнийг байгальд ээлтэйгээр устгахад хөрөнгө зардал их шаардлагатай байдаг ч орон нутагт хог хаягдалд зарцуулах хөрөнгө байдаггүй, иргэн, ААНБ-аас авах хогны хураамж зөвхөн аймгийн төвд л цахилгааны мөнгөтэй хамт хураадаг тул төвлөрөлт сайн байна. Хөдөө сумдад хогны жолооч явж ачсан хогны хэмжээгээр хураамж авдаг ч ачуулахаасаа ачуулахгүй өрхийн тоо их байна. Энэ асуудал дээр жил бүр сумдад чиглэл зөвлөмж өгч байгаа боловч 2017 оноос ажил сайжрахгүй байгаа нь хуулиар тодорхой үүргийг нь зааж өгсөн албан тушаалтнуудын мэдлэг, хандлага, хамтын ажиллагаа байхгүйгээс шалтгаалж байна.

Сүүлийн жилүүдэд ахисан нэг ажил бол сумдад хог тээврийн машин, бага оврын түрж булдаг техниктэй болж байгаа ажил юм.

Хогийн цэгт хаях хогны хэмжээг бууруулах, эзэнгүй хог хаягдлыг багасгах, иргэдийн ухамсар дадлыг зөв хэвшүүлэхэд хог хаягдлыг нэгдсэн журмаар тээвэрлэх, цуглуулах ажил чухал юм. Гэтэл хогны хураамжийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байгаатай холбоотой асуудал үүсч байна. Цаашид аймгийн төвд хог хаягдлын цэгийг түшиглэн дахин боловсруулах хог хаягдлын нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг цогцоор нь шийдсэн эко парк байгуулахад хувийн хэвшлийг дэмжих, хамтран ажиллаж, орон нутгаас шаардлагатай хөрөнгө санхүүг шат дараатайгаар тусгаж байх нь чухал байна.

Хог хаягдлыг бууруулахын тулд хамгийн их анхаарах зүйл бол иргэдийн ухамсар сэтгэлгээ, дадлыг өөрчлөх сургалт сурталчилгааг хийх, хөдөө орон нутаг хоёрдогч түүхий эд авах цэг, санаачилга гаргасан иргэндээ дэмжлэг үзүүлж, урамшууллын системийг бий болгох зэргээр ангилан ялгалтыг хэвшүүлж, эх үүсвэр дээрээ гаргах хогны хэмжээг бууруулж, ил задгай шатааж устгадаг асуудлыг зогсоох зайлшгүй шаардлагатай юм.

Иймд ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлэн хог хаягдлын менежментийг шинэ шатанд гаргаж нөөц, түүхий эдийн хэмнэлттэй, үр ашигтай, хаягдал багатай цэвэр технологийг дэмжих замаар хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, бохирдуулагч нь төлбөр төлөх, 3R (бууруулах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах) зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, хог хаягдлыг зайлуулах дэд бүтцийг бий болгох, чадавхийг бэхжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлж, бүх нийтийн оролцоотойгоор хамтдаа хог хаягдлыг бууруулж, цэвэр эрүүл орчинг бүрдүүлэх чиглэлээр зорилго, үйл ажиллагааг тодорхойлж нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## **Хоёр. Зорилго, зорилтууд**

2.1. Нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэл, технологийг дэмжин хаягдлыг бууруулж, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хатуу хог хаягдлын зохистой менежментийг төлөвшүүлж, цэвэр эрүүл орчин бүрдүүлэхэд үндсэн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг шийдвэрлэнэ:

2.2.1. Хог хаягдлын тухай хууль, журмаар иргэд, шат шатны албан тушаалтны хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх;

2.2.2. Үйлдвэрлэл, үйлчилгээний хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг дэмжинэ.

2.2.3. Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах, сэргээн ашиглах, байгальд ээлтэй аргаар устгах замаар хог хаягдлаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулна

2.2.4. Аюултай хог хаягдлыг хяналттай болгож, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах

2.2.5. Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал, сэтгэлгээг төлөвшүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх

## **Гурав. Хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт, эргүүлэн ашиглалтыг хөхүүлэн дэмжих;

3.1.2. Хог хаягдлыг байгаль орчинд хал багатай арга технологиор устгах;

3.1.3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үйлдвэрлэл дээр нь бууруулах;

3.1.4. Үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг тухайн үүсгэгчээр нь хариуцуулах, бохирдуулагч нь төлбөр төлөх;

3.1.5. Иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, түншлэлд тулгуурлах;

3.1.6. Гадаад орны хог хаягдлын менежментийн тэргүүн туршлагыг аймгийнхаа онцлогт тохируулан бүтээлчээр нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

## **Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**4.1. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

4.1.1. Хог хаягдлын тухай хуульд заасан тодорхой эрх, үүрэг бүхий албан тушаалтануудын оролцоог сайжруулах, чадавхижуулах

4.1.2. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах, дахин ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, иргэдийн бүлэг, аж ахуйн нэгжийг дэмжих

4.1.3. Хог хаягдлын тухай хууль, журмын хэрэгжилтийн талаар хяналт шалгалтыг эрчимжүүлэх

4.1.4. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нэмэгдүүлэх

4.1.5. Бүх сумд сумын онцлогт тохирсон хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөлттэй болж, хэрэгжүүлэх албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох

## **4.2. Хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

4.2.1. Үйлдвэрлэл, үйлчилгээний хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, хаягдалгүй, байгальд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжиж, хяналт, хариуцлагыг сайжруулна.

4.2.2. Дахин ашиглах боломжтой шилэн лонхыг худалдааны төвүүдээр дамжуулан эргүүлэн авч, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.

4.2.3. Томоохон үйлдвэрлэгч, үйлчилгээний газруудыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болгох

## **4.3. Хөтөлбөрийн 2.2.3-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

4.3.1. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг эко парк цогцолбор байдлаар байгуулахад төр хувийн хэвшил хамтран ажиллана.

4.3.2. Сумдаас дахивар нөөцийг цуглуулдаг тогтолцоог бүрдүүлэх

4.3.3. Эх үүсвэр дээр нь хогийг ангилан ялгаж хаях хогийн савыг нэвтрүүлж, ангилсан хог хаягдлыг тусд нь цуглуулан тээвэрлэдэг тогтолцоог бүрдүүлэх

4.3.4. Хог хаягдлын норматив хэмжээг тогтоох, хог хаягдлын тооллого явуулж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

4.3.5. Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгальд сөрөг нөлөө багатай технологи нэвтрүүлэх

4.3.6. Судалгааны үндсэн дээр сумдын хогийн цэгийн нэг загварын аргачлал, зураг төсөв боловсруулна.

4.3.7. Барилга, эрүүл мэнд, ХАА, дулаан, үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах

4.3.8. Хог тээврийн машин техникийн хүрэлцээг сайжруулна.

4.3.9. Судалгааны үндсэн дээр хог тээврийн машин техникийн хүрэлцээг сайжруулна.

4.3.10. Хог хаягдлын менежмент хөгжсөн улс орнуудын туршлага нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх

**4.4. Хөтөлбөрийн 2.2.4-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

4.4.1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах

4.4.2. Аюултай хаягдлын тооллого явуулах

4.4.3. Ахуйн аюултай хаягдлыг зүй зохистой хаядаг тогтолцоонд шилжих /цахим төхөөрөмж, аккумулятор, дугуй, малын сэг зэм/

4.4.4. Сумдын эрүүл мэндийн байгууллагаас гарч буй аюултай хаягдлыг зүй зохистой устгах

**4.5. Хөтөлбөрийн 2.2.5-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

4.5.1. ЕБС-иар дамжуулан тогтвортой хөгжлийн боловсрол болон хог хаягдлын талаарх зөв дадлыг эзэмшүүлнэ.

4.5.2. Мэргэжлийн багш, зөвлөхүүдтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш, бага ангийн багш нарыг чадавхижуулж, хүүхдэд байгаль орчны боловсрол олгоход хамтран ажиллана.

4.6.3. Хэвлэл мэдээллийн байгууллага болон сургалтаар дамжуулан олон нийтэд хог хаягдлын талаар мэдлэг өгнө.

4.6.4. Олон нийтийн компанит ажил, 3R зарчимын үйл ажиллагаанд залуу үеийнхэн, ТББ-ыг татан оролцуулах

4.6.5. Хөдөөгийн малчдын хог хаягдалтай зөв харьцах дадал, мэдлэгийг олгох, хэрэгжүүлэх

#### **Тав. Хэрэгжүүлэх хугацаа**

Төлөвлөгөө хэрэгжих хугацаа

(2018-2021 он)

#### **Зургаа. Санхүүжилт**

6.1. Төлөвлөгөөний санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 6.1.2. хог хаягдлын үйлчилгээний хураамж;
- 6.1.3. олон улсын байгууллага, хандивлагчийн зээл, тусламж;
- 6.1.4. аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах хөрөнгө;
- 6.1.5. бусад эх үүсвэр.

### **Долоо. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

7.1. Мастер төлөвлөгөө хэрэгжсэнээр хог хаягдлын зохистой менежментийн эхлэл тавигдаж, хот суурин газарт эрүүл ахуйн шаардлага хангасан төвлөрсөн хогийн цэгтэй болох, нийт хог хаягдлын 8-аас доошгүй хувийг эргүүлэн ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар дахин боловсруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшиж, хог хаягдлын урсгалын статистик мэдээ, цахим сан бүрдүүлэх, аюултай хог хаягдалыг хяналттай болгож, хүрээлэн буй орчид сөрөг нөлөөгүйгээр устгах чадавх бүрдсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2018 оны .....сарын .....ний өдрийн  
.....тоот тогтоолын 2-р хавсралт

**АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ  
2018-2021**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Арга зам	Шалгуур үзүүлэлт		Санхүүжилт		Хугацаа	Зохион байгуулагч	
			Хэмжих нэгж	Хүрэх үр дүн	Хэмжээ /сая.төг/	Эх үүсвэр		Үндсэн	Хамтрагч
<b>Нэг. Хог хаягдлын тухай хууль, журмаар иргэд, шат шатны албан тушаалтны хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх, хариуцлага, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх;</b>									
1.1	Хог хаягдлын тухай хуульд заасан тодорхой эрх, үүрэг бүхий албан тушаалтануудын оролцоог сайжруулах, чадавхижуулах	Сум, Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч, олон нийтийн байцаагчийн үр дүнгийн гэрээ, ажлын төлөвлөгөөнд тодорхой ажлыг тусгаж, дүгнэдэг болох	Тусгасан үйл ажиллагаа	Холбогдох албан тушаалтануудын оролцоо нэмэгдэж, чадавхижсан байна.	-	-	2018-2021	Сумын ЗДТГ, байгууллагын дарга нар	БОАЖГ
		ХТҮТөв дээр хог хаягдлын мэргэжлийн инженер техникийн ажилтантай болох	Орон тоо	ХХ-ыг цуглуулах, тээвэрлэх, ландфиллийн менежмент сайжирна.	-	ОНТ	2018	Сумын ЗДТГ, ХТҮТ	-
		Холбогдох албан тушаалтан, иргэдийн бүлгийг чадавхижуулах сургалт зохион байгуулна.	Сургалтын тоо	1-ээс доошгүй удаа сургалт хийж, холбогдох албан тушаалтнуудын мэдлэг дээшилнэ.	5,0	ОНТ	2018-2019	БОАЖГ	АЗДТГ

1.2	Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, дахин боловсруулах, дахин ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, иргэдийн бүлэг, аж ахуйн нэгжийг дэмжих	Сумын төв болон аймгийн төвийн баг бүр дээр хог хаягдлыг ангилах, цуглуулах, боловсруулах, ашиглах иргэдийн бүлэг байгуулахыг дэмжинэ.	Байгуулагдсан иргэдийн бүлгийн тоо	Аймгийн төвд 4-өөс доошгүй, сум бүрт 1 бүлэг байгуулах	-	ОНТ, ХХҮХур аамжийн орлого	2018-2021	Сум, багийн Засаг дарга	ТББ, Иргэдийн бүлэг
1.3	Хог хаягдлын тухай хууль, журмын хэрэгжилтийн талаар хяналт шалгалтыг эрчимжүүлэх	Жил бүрийн хяналт шалгалт, авсан арга хэмжээний мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ. МХГ, Цагдаа, олон нийтийн цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагчийн оролцоог нэмэгдүүлэх	Хяналт шалгалт, торгуулийн тоо хэмжээ	Иргэдийн хариуцлага нэмэгдэж, зөрчил буурсан байна.	-	-	2018-2021	МХГ, Цагдаагийн газар	Сум, багийн Засаг дарга, ОНЦагдаа,
1.4	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг нэмэгдүүлэх	Бүх сум хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоож, хог хаягдлын орлогыг төсөвт төвлөрүүлнэ.	Төвлөрүүлсэн хураамжийн хэмжээ	Хураамжийн хэмжээг нэмэгдүүлсэнээр хог хаягдалд зарцуулах мөнгө нэмэгдэнэ.	-	-	2018	Сумын Засаг дарга	АЗДТГ, БОАЖГ
1.5	Бүх сумд сумын онцлогт тохирсон хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөлттэй болж, хэрэгжүүлэх албан тушаалтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох	Сумд төлөвлөгөө боловсруулахад нь мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	Төлөвлөгөөтэй сумдын тоо	Сум бүр төлөвлөлттэй болсоноор хог хаягдлыг бууруулах үйл ажиллагаа идэвхижнэ.	-	-	2018-2021	Сумын Засаг дарга	БОАЖГ, ЭМГ
<b>Хоёр. Үйлдвэрлэл, үйлчилгээний хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, байгальд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг дэмжинэ.</b>									
2.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хог хаягдлын зохистой менежментийг бий болгож, хаягдалгүй, байгальд ээлтэй үйлчилгээг	Үйлдвэрлэл, үйлчилгээний хаягдлыг дахин ашиглах, боловсруулах туршлагыг нэвтрүүлэхэд бодлогоор дэмжинэ, /барилгын, хүнсний хаягдал, яс, баглаа боодол, гялгар уут г.м/	Үйлдвэрлэл, үйлчилгээний тоо	Байгальд хаягдах хогны хэмжээ буурч, ажлын байр нэмэгдэнэ.	-	-	2018-2021	ААНБ, үйлчилгэний газрууд, иргэд	Сумын ЗДТГ, ГХБХБГ, БОАЖГ, ҮХААГ



	нэвтрүүлэхэд дэмжиж, хяналт, хариуцлагыг сайжруулна.								
2.2	Дахин ашиглах боломжтой шилэн лонхыг худалдааны төвүүдээр дамжуулан эргүүлэн авч, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.	Үйлдэрлэгч, импортлогч, гэрээт борлуулагч, үйлдвэрлэгч нь тодорхой төрлийн хаягдлаа эргүүлэн татдаг тогтолцоонд шилжинэ.	Эргүүлэн цуглуулсан хаягдлын хэмжээ	Байгальд шингэж, устдаггүй хаягдлын хэмжээ буурна.	-	-	2018-2021	ААНБ-ууд	АЗДТГ, БОАЖГ, МХГ, сумдын ЗДТГ
2.3	Томоохон үйлдвэрлэгч, үйлчилгээний газруудыг хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болгох	Томоохон ХҮТ, үйлдвэрлэгчид, үйлчилгээний газрууд хог хаягдлын төлөвлөгөөг холбогдох байгууллагаар хянуулдаг болно.	Төлөвлөгөө хэрэгжүүлэгч байгууллагын тоо	Үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч буй хогны хэмжээ буурна.	-	-	2018-2021	ААНБ-ууд	БОАЖГ, МХГ,
<b>Гурав. Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах, сэргээн ашиглах, байгальд ээлтэй аргаар устгах замаар хог хаягдлаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулна</b>									
3.1	Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг эко парк цогцолбор байдлаар байгуулахад төр хувийн хэвшил хамтран ажиллана.	Төсөл бичих, ТЭЗҮ боловсруулах, төсөл, хөтөлбөрт хамруулахад төрийн байгууллагын зүгээс хамтран ажиллана.	Төслийн үе шат	Цогц байдлаар байгуулсанаар хогийг цуглуулах, ангилах, боловсруулах үйл ажиллагаа жигд явагдана.	ТЭЗҮ-ээр	Зээл, төсөл	2018-2021	ААН	АЗДТГ, БОАЖГ, Мөрөн сумын ЗДТГ
3.2	Сумдаас дахивар нөөцийг цуглуулдаг тогтолцоог бүрдүүлэх	Сум бүрт байгуулсан иргэдийн бүлэгээр дамжуулж дахиварыг цуглуулах	Сумын тоо	Сумдын хогийн цэгт хаягдах хогны хэмжээ буурна	-	-	2018-2021	ИААНБ, бүлэг	Сумын ЗДТГ
3.3	Эх үүсвэр дээр нь хогийг ангилан ялгаж хаях хогийн савыг нэвтрүүлж, ангилсан хог хаягдлыг тусд нь цуглуулан тээвэрлэдэг тогтолцоог бүрдүүлэх	Аймгийн төвийн бүх айл өрхөд хогийн савны загварыг сурталчилж, ангилах боломжтой хогийн савтай болох шаардлага тавьж, цуглуулалтыг нэвтрүүлнэ.	Хогийн савтай болсон өрхийн тоо	Хог хаягдлыг гудамжинд асгадаг, ангилдаггүй байдлыг бууруулна.	-	-	2018-2021	Иргэн, ААНБ, Мөрөн сумын ЗДТГ, ХТҮТөв	АЗДТГ, БОАЖГ
3.4	Хог хаягдлын	Бүх сумдад гарч буй хогны		Сумын хог					

	норматив хэмжээг тогтоох, хог хаягдлын тооллого явуулж, мэдээллийн сан бүрдүүлнэ.	норматив тогтоох судалгаа хийнэ.	Норматив тогтоосон сумын тоо	хаягдлын хэмжээ, бүтцийн мэдээлэлтэй болно.	3,6	ОНТ	2018-2019	Сумын ЗДТГ	БОАЖГ
3.5	Аймгийн төвийн төвлөрсөн хогийн цэгт байгальд сөрөг нөлөө багатай технологи нэвтрүүлэх	Шинээр хог асгах цэгийг хуулийн шаардлагад нийцсэн 2-р зэргийн ландфилл болгох төсөл бичиж, хөрөнгө санхүүг шийдэх	Хогийн цэгийн ангилал	Хогийн цэгээс орчинд үзүүлэх нөлөө буурна.	ТЭЗҮ-ээр	ОНТ, төсөл	2018-2020	Мөрөн сумын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ
3.6	Судалгааны үндсэн дээр сумдын хогийн цэгийн нэг загварын аргачлал, зураг төсөв боловсруулна.	Мэргэжлийн байгууллагаар зураг төсвийг боловсруулж, сумдад хүргүүлнэ.	Зураг төсөв боловсруулагдсан байна.	Шаардлагад нийцсэн хогийн цэгүүд бий болно.	3,0	ОНТ	2019	БОАЖГ	АЗДТГ
3.7	Барилга, эрүүл мэнд, ХАА, дулаан, үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Эдгээр салбаруудаас гарах хог хаягдлыг зохистой хаях, ашиглах, дахин боловсруулах, устгах журмыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагаа	Эрүүл мэнд, барилга, дулааны болон бусад үйлдвэрлэл, ХАА-н хог хаягдлын ашиглалт, устгалт сайжирна.		Улсын болон ОНТ	2018-2021	ГХБХБГ, ЭМГ, ХХААГ, ДС	АЗДТГ, холбогдох яамд, БОАЖГ,
3.8	Хог тээврийн машин техникийн хүрэлцээг сайжруулна.	Аймгийн төвд хог тээврийн зориулалтын машины тоог нэмэгдүүлнэ.	Зориулалтын тээврийн хэрэгслийн тоо	Хог тээврийн ажиллагаа үр дүнтэй болно.	450,0	ОНТ	2018-2021	Сумын ЗДТГ	АЗДТГ
3.9	Хог хаягдлын менежмент хөгжсөн улс орнуудын туршлага нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хог хаягдлын менежментээр дээгүүрт ордог улсад туршлага судлах, сайн дурын ажилтан авч ажиллуулах талаар судалж, шийдвэрлэнэ.	Үйл ажиллагаагаар	Дэвшилтэт санал санаачилга нэвтрүүлсэн байна.	-	-	2018-2021	ИТХ, АЗДТГ,	БОАЖГ, Мөрөн сумын ЗДТГ
<b>Дөрөв. Аюултай хог хаягдлыг хяналттай болгож, байгаль орчинд хал багатайгаар зайлуулах</b>									
	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын	Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг сар бүр аюулгүй	Зориулалты	Аюултай хаягдал	50,0	Хувийн хэвшил,	2018-2021	Сумын ЗДТГ,	АЗДТГ

4.1.	менежментийг сайжруулах	тээвэрлэх автомашин ариутгах автоклавтай болгож, хувийн ААН болон ХТҮТ-д нэгж байгуулж гүйцэтгүүлэхийг дэмжинэ.	Н байгууламжийн тоо	хяналттай болно.		ОНТ, төсөл хөтөлбөр		ЭМГ	
4.2.	Аюултай хаягдлын тооллого явуулах	Аюултай хаягдлын эх үүсвэрийг бүртгэлжүүлж, хяналттай болгох ажлыг давтамжтай хийх	Аюултай хаягдлын хяналттай цэгийн тоо	Аюултай хаягдлыг зөвшөөрөлтэй цэгт хаягддаг болгоно.	5,0	-	2018-2021	Сумын ЗДТГ	БОАЖГ, МХГ
4.3.	Ахуйн аюултай хаягдлыг зүй зохистой хаядаг тогтолцоонд шилжих /цахим төхөөрөмж, аккумулятор, дугуй, малын сэг зэм/	Ахуйн аюултай хаягдлын талаар холбогдох байгууллага, иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, халдваргүйжүүлэх, аюулгүй цуглуулалт, тээвэрлэлтийг дэмжинэ	Аюултай хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тогтолцоо	Ахуйн аюултай хаягдлаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө буурна.	-	ОНТ	2020-2021	АЗДТГ, БОАЖГ	МХГ, ЭМГ... Сумын ЗДТГ
4.4.	Сумдын эрүүл мэндийн байгууллагаас гарч буй аюултай хаягдлыг зүй зохистой устгах	Бүх сумын ЭМТ-үүдийг аюултай хаягдал ариутгагч автоклавтай болгох	Автоклавтай сумын тоо	Аюултай хаягдлыг шатаадаг зөрчил үгүй болно.	240.0	ОНТ	2018-2021	Сумын ЭМТ, ЭМГ	Сумын ЗДТГ
<b>Тав. Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал, сэтгэлгээг төлөвшүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх</b>									
5.1.	ЕБС-иар дамжуулан тогтвортой хөгжлийн боловсрол болон хог хаягдлын талаарх зөв дадлыг эзэмшүүлнэ.	Эко сургууль болон ЕБС-ийн эко бүлгийг чадавхижуулж, түүгээр дамжуулан олон нийтийн идэвхи санаачилгыг өрхүүлэх, мэдээлэл түгээх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих	Үйл ажиллагааны үр дүнгээр	Хог хаягдлын талаарх дадал өөрчлөгдсөн байна.	12,0	ОНТ, төсөл хөтөлбөр	2018-2021	Аймаг, сумдын ЗДТГ, БСУГ, БОАЖГ	ТББ-ууд, ЕБС-иуд
5.2.	Мэргэжлийн багш, зөвлөхүүдтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын багш, бага ангийн багш нарыг чадавхижуулж, хүүхдэд байгаль	Бага ангийн болон СӨБ-ын багш нарыг чадавхижуулах, сургагч багш бэлтгэх зэргээр хог хаягдлын талаарх мэдлэг, дадлыг хүүхдэд эзэмшүүлнэ.	Багш нарын үйл ажиллагаагаар	Хүүхдэд багаас нь хог хаягдлын талаар зөв дадал эзэмшүүлнэ	2,0	ОНТ	2018-2021	БСУГ	БОАЖГ, ТББ-ууд

	орчны боловсрол олгоход хамтран ажиллана.								
5.3.	Хэвлэл мэдээллийн байгууллага болон сургалтаар дамжуулан олон нийтэд хог хаягдлын талаар мэдлэг өгнө.	Зорилтот мэдээ, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэх	Нэвтрүүлгийн тоо давтамж	Олон нийтийн мэдлэг дээшилнэ	1,2	ОНТ	2018-2021	БОАЖГ	Сумын ЗДТГ
5.4.	Олон нийтийн компани ажил, 3R зарчмын үйл ажиллагаанд залуу үеийнхэн, ТББ-ыг татан оролцуулах	Насан туршийн боловсролын багш, бэлтгэгдсэн сургагч багш, ТББ, сайн дурын клубуудыг оролцуулах	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Олон нийт, залуучуудын оролцоо, хандлага өөрчлөгдөнө.	24,0	ОНТ	2018-2021	Аймаг, сумын ЗДТГ,	БОАЖГ, ТББ, олон нийтийн байгууллагууд
5.5.	Хөдөөгийн малчдын хог хаягдалтай зөв харьцах дадал, мэдлэгийг олгох, хэрэгжүүлэх	Малчдад мэдээлэл өгч, ойролцоох газруудыг хариуцуулан хог хаягдлыг цэвэрлүүлж хэвших	Малчдын үйл ажиллагаа	Хөдөөгийн малчдын нутагладаг газрууд хог хаягдалгүй болно	-	-	2018-2021	Сумын ЗДТГ	

\* \* \*